



**Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлж буй иргэдээс
авсан 2024 оны 01 сарын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл**

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын газр үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс хүлээж буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ


- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээний А заал 101 тоотоос иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.




СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Зураг1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс



Дүгнэлт: Орхон аймаг Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаанд 110 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 68 иргэн буюу 61.8% эмэгтэй, 42 иргэн буюу 38.2% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.


График1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн насны хувьд авч үзвэл 20 хүртэлх насны 4 иргэн буюу 3.6% , 20-29 насны 19 иргэн буюу 17.3% , 30-39 насны 33 иргэн буюу 30 % ,40-49 насны 30 иргэн буюу 27.3% , 50-59 насны 21 иргэн буюу 19.1%, 60-аас дээш насны 3 иргэн буюу 2.7% тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.




График2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээний төрөл



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 110 иргэдийн тэтгэвэртэй холбоотой үйлчилгээг 23 иргэн буюу 20.9%, тэтгэмж 10 иргэн буюу 9.3%, сайн дурын даатгал 29 иргэн буюу 26.4%, нийгмийн даатгалын шимтгэл 7 иргэн буюу 6.4%, зөвлөгөө мэдээлэл 16 иргэн буюу 14.5%, бусад 25 иргэн буюу 22.7% тус бүр байна.

График3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ шуурхай, хялбар



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн 43 даатгуулагч маш сайн үнэлгээг өгсөн (39.1%), сайн үнэлгээг 63 даатгуулагч буюу (57.3%), дунд үнэлгээг 4 даатгуулагч буюу (3.6%), муу үнэлгээг өгөөгүй байна.




Зураг2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл авсан үнэлгээ



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн “Тийм” гэсэн үнэлгээг 110 иргэн буюу (100%), “Үгүй” гэсэн үнэлгээг сонгоогүй байна.

Зураг 3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн зөвлөгөө, ажилтны харилцаа, хандлага үнэлгээ



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн сэтгэл ханамжтай 107 иргэн буюу (97.3%), сэтгэл ханамжгүй 3 иргэн буюу 2.4% тус бүр өгсөн байна.



Зураг4:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл ил тод байдал\Төлөвлөгөө, тайлан, хүний нөөц,худалдан авах ажиллагаа ..\



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 110 иргэдийн “Тийм” үнэлгээг 1 иргэн буюу (0.5%), “Үгүй” үнэлгээг 14 иргэн буюу (12.7%), Мэдэхгүй үнэлгээг 95 иргэн буюу (86.4%) тус бүр үнэлсэн байна.


График4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн ойр дотны хамаатан садан, найз нөхөд ажилладаг бол түүгээр дамжуулан



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 110 иргэдийн “Тийм” үнэлгээг 1 иргэн буюу (0.5%), “Үгүй” үнэлгээг 109 иргэн буюу (99.1%) тус бүр үнэлсэн байна. Энэ нь иргэд эрх тэгш үйлчилгээг дэс дараалалттай авч байна. Тийм хэмээн хариулсан 1 иргэн каноны үйл ажиллагааны хураамжыг ойлгосон хэмээн авч үзэж байна.



График5: Түүвэр судалгаанд оролцсон иргэд үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг өгөх, хандив туслалцаа үзүүлж байсан уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон “Үгүй” үнэлгээг 110 иргэн буюу (100%) тус бүр үнэлсэн байна.

Та төрийн байгууллагын авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх хэрэгтэй гэж үзэж байна вэ?



- ✓ Баярлалаа
- ✓ Баярлалаа
- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээ цахим хялбар болсон байна
- ✓ Ур чадвар сайтай
- ✓ Харилцааны соёл сайн байна
- ✓ Алданга тооцохгүй байх
- ✓ Маш сайн үйлчилсэн
- ✓ Ил тод байлгах
- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээ хялбар байсан

Судалгааны нэгтгэл хийсэн:/Ө.Нэргүй /